




АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ТАТВАРЫН АЧААЛАЛ БА ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛТИЙН СУДАЛГАА



2013 он



Зохиогчид:**Судалгааны ажлыг боловсруулсан:**

АМГ -ын УУХ-ийн НЭЗСТ-ийн дарга	Б.Бямбадагва
АМГ -ын УУХ-ийн ахлах мэргэжилтэн	Ц.Цэгц
АМГ -ын УУХ-ийн мэргэжилтэн	Ц.Золзаяа

Хаяг:

Монгол Улс, Улаанбаатар 211238, Шуудангийн салбар 38,
Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр,
Баруун жигүүр, Ашигт Малтмалын Газар,
Уул уурхайн хэлтэс

Утас: 976-11-263918
Факс: 76-11-310041
E-mail: zolzaya@mram.gov.mn
Web page: <http://www.mram.gov.mn>

АГУУЛГА

Удиртгал

1. Монгол Улсын Уул уурхайн салбарын татварын өнөөгийн байдал ба шинэчлэл
 - Уул уурхайн салбарт мөрдөгдөж буй хуулиуд
 - Уул уурхайн салбараас авч буй татвар, төлбөр
 - Уул уурхайн салбарын татварын өөрчлөлт, шинэчлэлт
 - Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
 - Ус ашигласны төлбөр
 - Нэмэгдсэн өртгийн албан татвар
 - Агаарын бохирдлын төлбөр
2. Уул уурхайн салбараас улс, орон нутгийн төсөвт оруулсан орлого
3. Монгол Улсын Уул уурхайн салбарын татварын ачааллын судалгаа
4. Хураамжийн судалгаа

Дүгнэлт

Ашигласан материал

УДИРТГАЛ

Уул уурхайн салбарын татварын орчны судалгааг Уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн уулын ажлын тайлан ба Үндэсний статистикийн хорооноос гаргасан “Монгол улсын статистикийн эмхтгэл”-ийг үндэслэн бэлтгэлээ.

Уул уурхайн салбар нь 2012 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 22,8%, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 70,6%, экспортын бүтээгдэхүүний 87,7%-ийг эзэлж байгаа нь тус улсын эдийн засагт чухал байр суурь эзэлж байгаа бөгөөд энэ нь манай улсын эдийн засгийн үзүүлэлтүүдэд уул уурхайн салбар шууд нөлөө үзүүлсээр байна.

Уул уурхайн үйлдвэрлэл нь эдийн засгийн эрсдэл өндөртэй, нөхөн сэргээлт байгаль орчны тогтвортой байдлыг хангахад их хэмжээний хөрөнгө зарцуулдгаараа бусад салбаруудаас онцлог юм.

Иймд хөрөнгө оруулалт татахын тулд татварын орчин тогтвортой байх нь урт хугацаанд салбарыг хөгжүүлэх чухал үзүүлэлт болдог.

1. Уул уурхайн салбарын татварын эрх зүйн орчны өнөөгийн байдал ба шинэчлэл

Улс, орон нутгийн эдийн засгийн хөгжлийг тодорхойлж буй уул уурхайн салбарын татварын эрх зүйн орчин нь аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалтыг нь нэмэгдүүлхийн зэрэгцээ татварын хэмжээг оновчтой тогтоож улсын төсөвт татварыг тогтвортой төвлөрүүлэхэд чиглэнэ.

Уул уурхайн салбарт мөрдөгдөж буй хууль

Монгол улсын Уул уурхайн салбарын үйл ажиллагааг эрх зүйн хувьд зохицуулах дараах хуулиуд хэрэгжиж байна. Үүнд:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль
- Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль
- Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль
- Газрын хэвлийн тухай хууль
- Газрын тухай хууль
- Газрын төлбөрийн тухай хууль
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлохыг хориглох тухай хууль
- Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Ойн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Усны тухай хууль
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль
- Цөмийн энергийн тухай хууль бусад холбогдох хууль тогтоомж

Уул уурхайн салбараас авч буй татвар, төлбөр

Монгол улсын уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нь дараах татвар, төлбөр, хураамжийг улсын болон орон нутгийн төсөвт оруулж байна.

Улс орон нутгийн төсөвт оруулж байгаа татвар, төлбөр

Хүснэгт - 1

д/д	Татварын төрөл	Улс	Аймаг	Сум
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	√		
2	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	√	√	
3	Авто тээврийн болон өөрөө явах хэрэгслийн албан татвар		√	
4	Нэмэгдсэн өртгийн албан татвар	√		
5	Импортын барааны гаалийн татвар	√		
6	Онцгой албан татвар	√		
7	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	√		
8	Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	√		
9	Газар ашигласны төлбөр		√	√
10	Ус ашигласны төлбөр	√		√
11	Зам ашигласны төлбөр		√	
12	Агаарын бохирдлын төлбөр	√		
13	Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөр		√	
14	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	√	√	
15	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	√		
16	Хүн амын орлогын албан татвар		√	√

Уул уурхайн салбарт хэрэгжиж буй татварын хувь хэмжээний өөрчлөлт нь уул уурхайн салбарын үйлдвэрлэл, мөн гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээнд шууд хамааралтай байдаг.

Монгол улсад хүчин төгөлдөр байгаа татвар, төлбөр хураамж, тэдгээрийн хувь хэмжээг хүснэгт 2-т харуулав.

Уул уурхайн салбарын татвар, төлбөрийн орчны судалгаа

Хүснэгт -2

л/д	Хууль болон татварын төрөл	2003	2004-2005	2006-2008	2009-2010	2011	2012
Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр /ам.доллар/га/							
1	1 жил	0.01			0.1		
	2 жил	0.5			0.2		
	3 жил	0.5			0.3		
	4-5 жил	1			1		
	6 жил	1.5			1		
	7-9 жил	1.5			1.5		
Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр /ам.доллар/га/							
2	1-3 жил	5		Жил харгалзахгүй 15\$ байх бөгөөд нүүрс болон түгээмэл тархацтай ашигт малтмалын хувьд гектар тутамд 5\$ байна.			
	4-6 жил	7.5					
	7 ба түүнээс дээш жил	10					
2	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	Борлуулалтын орлогод ногдуулна. Алтны үндсэн орлод 2,5%, шороон орлод 7,5%, бусад орлод 2,5%		Борлуулалтын үнэлгээнд ногдуулна. Дотоодод борлуулж байгаа нүүрс болон түгээмэл тархацтай орлод 2,5%, бусал ашигт малтмал болон экспортод гаргаж байгаа бүтээгдэхүүнд 5%		АМТХ-ийн 47.5-д заасан нэмж ногдуулах төлбөрийн хувь хэмжээгээр.	
3	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар			Зэсийн баяжмал болон алтны дэлхийн зах зээлийн үнэ эзэнд 2600\$/тн, алтанд 500\$/унци-аас дээш болсон тохиолдолд үүнээс дээш гарсан үнийн дүнгийн зөрүүнээс олсон орлогод 68%-ийн татвар ноогдуулна.	Зэсийн баяжмалд 2600\$/тн, алтанд 850\$/унци-аас дээш гэж өөрчилсөн.	Хүчингүй болсон.	
4	Хүн амын орлогын албан татвар	200 мянга хүртэл 10%, 200-400 мянга хүртэл 30%, 400 мянгаас дээш 30%			Шатлал харгалзахгүй 10%		
5	Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль	0-100 сая-15%, >100сая-40%	0-100 сая-15%, >100сая-30%		0-3 тэрбум -10%, > 3 тэрбум-25%		
6	Нэмэгдсэн өртгийн албан татвар	>10 сая-15%, <10 сая 0%, Алт-0%			Шатлал харгалзахгүй 10%, Алт-0% Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12.5-д заасны дагуу уул уурхайн эцсийн 17 бүтээгдэхүүний жагсаалтыг /экспортод гаргахад НӨАТ-ыг тэглэх/ Засгийн газрын 2010 оны 286 дугаар тогтоолоор баталсан.		
7	Үл хөдлөх хөрөнгийн татвар	2%					
8	Автобензин, дизель, түлшний онцгой албан татвар	Автобензин-90 хүртэл октантай-20350 төг/тн, 90-ээс дээш октантай-25700 төг/тн, дизель түлш-2140 төг/тн.			Хүчингүй болсон.		
9	Ус ашигласны төлбөр	Гадаргын болон гар худгийн 1-5 төг/м3, газрын гүний ус / үйлдвэрлэл /-1-20 төг/м3	Газрын гадаргын ба гүний ус 100-150 төг/м3			Газрын гадаргын ба гүний ус 826.2-13,216 төг/м3	
10	Газар ашигласны төлбөр					Тухайн орон нутгийн төрийн байгууллагын тодорхойлсон үнэлгээний 0,01-0,03 хувиар, орон нутгийн төсөвт төлнө.	
11	Агаарын бохирдлын хэмжээ					Олборлосон түүхийн нүүрсний төлбөрийн хувь, хэмжээг нүүрсний килограмм тутамд 1-2 төгрөгийн хязгаарт багтаан Засгийн газар тогтооно.	
12	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	Борлуулалтын орлогын 2.5 хувь		Борлуулалтын үнэлгээний 2.5 хувь		Борлуулалтын үнэлгээний 2.5-5 хувь байна. Хувийг Аймаг, нийслэлийн ИТХ тогтооно. /2013.01.01-нээс мөрдөнө/	

Уул уурхайн салбарын татварын өөрчлөлт, шинэчлэлт

Сүүлийн жилүүдэд уул уурхайн үйлдвэрлэлтэй холбоотой татвар төлбөрүүдийн хувь хэмжээ, тооцох аргачлалд өөрчлөлт орж шинэ төрлийн төлбөр нэмэгдэн гарч ирснийг татвар тус бүрээр нь доор үзүүлэв.

- **Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр**

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг заасан болно. Энэ хуулийн 47.5 дугаар зүйлд өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийн хэмжээг заасан байдаг.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, борлуулалтын үнэлгээг тооцоход Монгол улсын Засгийн газрын 2007 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 88 дугаар тогтоолоор батлагдсан “Биржийн нэр зарлах”, Сангийн сайдын 2007 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Жишиг үнэ хэрэглэх аргачлал”, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 193 дугаар тогтоолоор батлагдсан “Аргачлал батлах тухай” тус тус тогтоолуудаар баталсан ба энэ тогтоолын хавсралтыг 2013 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор өөрчилсөн. Татварын ерөнхий газрын даргын 2010 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 322 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг тооцох аргачлал” гэх мэт тогтоол, журам, аргачлалуудыг мөрдөж байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тооцохдоо борлуулалтын орлогоос тухайн өдрийн биржийн зарлагдсан ханшыг тухайн бүтээгдэхүүний агуулгаар тооцож авах ба дээр нь Ашигт малтмалын хуулийн 47.5 -д заасны дагуу өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр тооцно.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5-5 хувьтай тэнцүү байна.

- **Ус ашигласны төлбөр**

Монгол улсын усны нөөц бүс нутгаар өөр үнэлгээтэй болсон. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн ус, рашаан ашигласны төлбөрийг тооцохдоо Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолыг баримталж тооцно. Засгийн газрын 302 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүснэгтээр үзүүлэв.

Усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ
(төгрөг/шоометр)

Хүснэгт -3

№	Монгол орны усны сав газар	Гадаргын ус	Газар доорхи ус
1	Сэлэнгэ мөрний сав газар	1050	4072
2	Хөвсгөл нуур, Эгийн голын сав газар	1507	1438
3	Шишхэд голын сав газар	1050	1337
4	Дэлгэрмөрөнгийн сав газар	1050	1510
5	Идэр голын сав газар	918	1510
6	Чулуут голын сав газар	918	1510
7	Хануй голын сав газар	1347	2311
8	Орхон голын сав газар	2783	4945
9	Туул голын сав газар	2651	9440
10	Хараа голын сав газар	2183	2764
11	Ерөө голын сав газар	1424	2764
12	Онон голын сав газар	1225	1663
13	Улз голын сав газар	1478	2780
14	Хэрлэн голын сав газар	1791	2835
15	Буйр нуур, Халх голын сав газар	2097	2081
16	Мэнэнгийн талын сав газар	1013	3700
17	Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар	1420	3700
18	Галба-Өөш Долоодын говийн сав газар	1420	3996
19	Онги голын сав газар	2240	3250
20	Алтайн өвөр говийн сав газар	1410	4433
21	Таац голын сав газар	1410	1939
22	Орог нуур, Түйн голын сав газар	1410	1939
23	Бөөнцагаан нуур, Байдраг голын сав газар	1522	2352
24	Хяргас нуур, Завхан голын сав газар	1675	2716
25	Хүйсийн говь, Цэцэг нуурын сав газар	1122	2352
26	Үенч Бодонч голын сав газар	800	2506
27	Булган голын сав газар	800	1729
28	Хар нуур, Ховд голын сав газар	1747	2506
29	Увс нуур, Тэс голын сав газар	1195	2506

**Тайлбар: Усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээг 2 дугаар хавсралтад заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүрээр үржүүлж гаргана.*

Усыг ямар зориулалтаар ашиглахаас хамаарч итгэлцүүр тооцож байгаа болно. Монгол улсын Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг үзүүлэв.

Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр

Хүснэгт - 4

№	Монгол орны усны сав газар	Гадаргын ус						Газар доорхи ус				
		Мал аж ахуй	Үйлдвэр	Хүн амын унд, ахуйн хэрэгцээ	Ногоон байгуул амжийн усалгаа	Газар тариалан	Амралт, аялал жуулчлал	Ногоон байгуул амжийн усалгаа	Хүн амын унд, ахуйн хэрэгцээ	Мал аж ахуй	Газар тариалан	Үйлдвэр
1	Сэлэнгэ мөрний сав газар	0.8	0.9	1	1	1.1	1.6	0.8	1	1.2	1.2	1.4
2	Хөвсгөл нуур, Эгийн голын сав газар	0.8	0.9	1	1	1.1	2.4	0.8	1	1.2	1.2	1.4
3	Шишхэд голын сав газар	0.8	0.9	1	1	1.1	2.4	0.8	1	1.2	1.2	1.4
4	Дэлгэрмөрөнгийн сав газар	0.8	0.9	1	1	1.1	1.6	0.8	1	1.2	1.2	1.4
5	Идэр голын сав газар	0.8	0.9	1	1	1.1	1.6	0.8	1	1.2	1.2	1.4
6	Чулуут голын сав газар	0.8	0.9	1	1	1.1	1.6	0.8	1	1.2	1.2	1.4
7	Хануй голын сав газар	0.8	0.9	1	1	1.1	1.6	0.8	1	1.2	1.2	1.4
8	Орхон голын сав газар	0.8	0.9	1	1	1.1	1.6	0.8	1	1.2	1.2	1.4
9	Туул голын сав газар	0.8	0.9	1	1	1.1	1.6	0.8	1	1.2	1.2	1.4
10	Хараа голын сав газар	0.8	0.9	1	1	1.1	1.6	0.8	1	1.2	1.2	1.4
11	Ерөө голын сав газар	0.8	0.9	1	1	1.1	1.6	0.8	1	1.2	1.2	1.4
12	Онон голын сав газар	0.8	0.9	1	1	1.1	1.6	0.8	1	1.2	1.2	1.4
13	Улз голын сав газар	0.8	0.9	1	1	1.1	1.6	0.8	1	1.2	1.2	1.4
14	Хэрлэн голын сав газар	0.8	0.9	1	1	1.1	1.6	0.8	1	1.2	1.2	1.4
15	Буйр нуур, Халх голын сав газар	0.8	0.9	1	1	1.1	2.4	0.8	1	1.2	1.2	1.4
16	Мэнэнгийн талын сав газар	1			1			0.4	0.7	1.2	1.6	2.2
17	Умард говийн гүвээт-Халхын дундал талын сав газар	1			1			0.4	0.7	1.2	1.6	2.2
18	Галба-Өөш Долоодын говийн сав газар	1			1			0.4	0.7	1.2	1.6	2.2
19	Онгиг голын сав газар	1	1.2	1	1	1.1	1.4	0.4	0.9	1.2	1.6	2.2
20	Алтайн өвөр говийн сав газар	1		1	1			0.4	0.9	1.2	1.6	2.2
21	Таац голын сав газар	1	1.2	1	1	1.1	1.4	0.4	0.9	1.2	1.6	1.8
22	Орог нуур, Түйн голын сав газар	1	1.2	1	1	1.1	1.4	0.4	0.9	1.2	1.6	1.8
23	Бөөнцагаан нуур, Байдраг голын сав газар	1	1.2	1	1	1.1	1.4	0.4	0.9	1.2	1.6	1.8
24	Хяргас нуур, Завхан голын сав газар	1	1.2	1	1	1.1	2.1	0.4	0.9	1.2	1.6	1.6
25	Хүйсийн говь, Цэцэг нуурын сав газар	1			1			0.4	0.8	1.2	1.6	1.6
26	Үенч Бодонч голын сав газар	1	1.2	1	1	1.1	1.4	0.4	0.8	1.2	1.6	1.6
27	Булган голын сав газар	1	1.2	1	1	1.1	1.4	0.4	0.9	1.2	1.6	1.4
28	Хар нуур, Ховд голын сав газар	1	0.9	1	1	1.1	2.4	0.4	0.9	1.2	1.6	1.4
29	Увс нуур, Тэс голын сав газар	1	0.9	1	1	1.1	1.6	0.4	0.9	1.2	1.6	1.4

*Тайлбар:

Улсын тусгай хамгаалалттай газар нутагт ус ашигласан тохиолдолд экологийн итгэлцүүрийг 2 дахин өсгөж тооцно.

Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй нэг бүс нутагт ус ашигласны төлбөрийг

хэрхэн тооцох талаар жишээн дээр тайлбарлаж үзүүлвэл: Заамрын бүсийн алтны ордын усны тооцоог бодож үзвэл жилдээ нийтдээ 50 мян.м3 элс олборлож угаахаар төлөвлөөд байна.

Тухайн алтны шороон ордод элс баяжуулах технологийн тооцоог баримталж шаардагдах усны 70%-ийг технологийн эргэлтийн усаар хангах ба 30%-ийг гадаргын цэвэр усаар сэлбэнэ гэж тооцоод ус ашигласны төлбөрийг бодож үзье.

Угаах үйл ажиллагаанд зарцуулагдах жилийн усны хэрэгцээг тооцвол:

$$V_{\text{ус}} = V_{\text{элс}} * Y_{\text{ус}} = 20,000.0 \text{ м}^3 * 4.0 \text{ м}^3/\text{м}^3 = 80,000.0 \text{ м}^3$$

$V_{\text{ус}}$ – тухайн жилд хэрэглэгдэх ус

$V_{\text{элс}}$ – тухайн жилд угаах элс

$Y_{\text{ус}}$ – 1м³ улс угаахад шаардлагатай усны хэмжээ

Сэлбэх цэвэр усны хэмжээ:

$$V_{\text{цэвэр}} = V_{\text{ус}} * q = 80,000 \text{ м}^3 * 30\% = 24,000.0 \text{ м}^3$$

$V_{\text{цэвэр}}$ – жилд хэрэглэгдэх цэвэр ус

q – сэлбэлтийн хувь

Тухайн уурхайн төлбөр тооцох нийт усны хэмжээ нь 24 мян.м³ гэж үзвэл Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор батлагдсан суурь үнэлгээнээс Туул голын сав газрын үнэлгээг (тухайн жишээний хувьд гадаргын усыг хэрэглэнэ) тухайн жилд хэрэглэгдэх цэвэр усны хэмжээгээр үржүүлээд ашиглалтын зориулалт тооцох итгэлцүүрээр үржүүлэхэд тухайн жилд төлвөл зохих төлбөрийн хэмжээ гарна.

$$T_{\text{ус}} = V_{\text{цэвэр}} * k * P_{\text{суурь}} = 24,000 \text{ м}^3 * 2651 \text{ төгрөг}/\text{м}^3 * 0.9 = 57,261,600.0 \text{ төгрөг}$$

$T_{\text{ус}}$ – жилд төлөх төлбөр

$V_{\text{цэвэр}}$ – жилд хэрэглэгдэх цэвэр ус

k – суурь үнэлгээ

$P_{\text{суурь}}$ – зориулалт тооцох итгэлцүүр

Ус ашигласны төлбөрийг усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ болон усны зориулалт тооцох итгэлцүүрээр тооцож үзэхэд 1 шоо метр ус ашиглахад төлбөр 826.2 төгрөгөөс 13,216.0 төгрөгийн хооронд хэлбэлзэж байна.

• **Нэмэгдсэн өртгийн албан татвар**

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12.1.7-д экспортод гаргасан уул уурхайн эцсийн бүтээгдэхүүнийн албан татварын тэг “0” хувиар тооцох болсон. Энэ хуулийн 12.5-д экспортод гаргасан уул уурхайн эцсийн бүтээгдэхүүний нэр төрөл, ангилал, кодыг Засгийн газар тогтооно.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12.5-д заасны дагуу уул уурхайн эцсийн 17 бүтээгдэхүүний жагсаалтыг (экспортод гаргахад НӨАТ-ыг тэглэх) Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 286 дугаар тогтоолоор баталсан.

**Нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” төгрөгөөр тооцох
уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн**

Хүснэгт -6

№	Код	Бүтээгдэхүүний нэр	Тайлбар
1	2612.10.00	Ураны баяжмал	Шар нунтаг /ураны хүдрийг баяжуулж гаргаж авсан шар нунтаг/
2	2613.10.20	Молибденийн улайсан боловсруулсан баяжмал	Молибдений баяжмалыг боловсруулах замаар гаргаж авсан бүтээгдэхүүн /чанаржуулсан гангийн найрлагад ордог/
3	2825.70.00	Молибденийн исэл	Молибдений баяжмалыг боловсруулах замаар гаргаж авсан бүтээгдэхүүн /чанаржуулсан гангийн найрлагад ордог/
4	2701.19.00	Угааж баяжуулсан нүүрс Чулуун нүүрснээс гаргаж авсан брикет, шахмал нүүрс болон эдгээртэй төстэй хатуу түлш	-
5	2701.20.00	Чулуун нүүрсний кокс болон хагас кокс	-
6	2704.00.10	Хүрэн нүүрсний кокс болон хагас кокс	-
7	2704.00.20	Хүрэн нүүрсний кокс болон хагас кокс	-
8	2706.00.00	Нүүрсний давирхай	Кокс үйлдвэрлэхэд гардаг дайвар бүтээгдэхүүн /химийн үйлдвэрт хэрэглэдэг/
9	2805.30.00	Газрын ховор металлын баяжмал	Газрын ховор элемент агуулсан хүдрийг баяжуулан гаргаж авсан болон химийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүн. Бүтээгдэхүүн дэх газрын ховор элементүүд болон тэдгээрийн ислийн нийлбэр агуулга нь хүдрийн гарал үүсэл, эрдсүүдийн шинж чанар, агуулгаас хамааран 60 %-аас багагүй байх.
10	7901.11.00	Хольцгүй цайр	Жингийн 99.99 хувьд цайр агуулсан байх
11	7203.10.00	Төмрийн хүдрийн шууд ангижруулах замаар гаргаж авсан төмөрлөг бүтээгдэхүүн	Баяжуулсан хүдрээс гаргаж авсан хорголжин болон тэдгээртэй адил төст хэлбэртэй бүтээгдэхүүн /80%-аас дээш металл төмрийн агууламжтай/
12	7106.92.00	Хайлж цэвэршүүлсэн мөнгө	999 сорьцтой байх
13	7403.11.00	Катодын зэс	-
14	7601.10.00	Хольцгүй хөнгөн цагаан	-
15	8001.10.00	Хольцгүй цагаан тугалга	-
16	2529.21.20	Хайлуур жоншны баяжмал /фторт кальцийн агууламж 95% буюу түүнээс дээш/	2529.21.20 кодоод хамаарах жоншны баяжмалуудаас фторт кальцийн бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүний жагсаалтад хамруулах бөгөөд 95%-аас доош агууламжтай бүтээгдэхүүн нь 2529.21.20 кодоод хамаардаг боловч энэ жагсаалтад орохгүй
17	78.04	Хольцгүй хар тугалга	-

• Агаарын бохирдлын төлбөр

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан. Энэ хуулиар дараах биет нэгжийг үндэслэн төлбөрийг тооцно. Үүнд:

1. Олборлосон түүхий нүүрсний төлбөр /килограммаар/
2. Үйлдвэрлэсэн болон импортлосон органик уусгагчийн төлбөр /килограммаар/
3. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн төлбөр/граммаар/
4. Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт гарах хаягдлын бохирдуулах төлбөр /килограммаар/ тус тус Засгийн газар тооцно.

Олборлосон түүхий нүүрсний төлбөрийн хувь, хэмжээг нүүрсний килограмм тутамд 1-2 төгрөгийн хязгаарт багтаан мөн үйлдвэрлэсэн болон импортлосон органик уусгагчийн төлбөрийн хувь, хэмжээг органик уусгагчийн килограмм тутамд 10-30 төгрөгийн хязгаарт багтсан ба агаарын бохирдлыг томоохон суурин эх үүсвэрээс агаарт гаргах хаягдлын бохируулах бодисын төлбөрийн хувь, хэмжээг килограмм тутамд 1-10 төгрөгийн хязгаарт багтаан Засгийн газар тус тус тогтооно. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн төлбөрийг тэдгээрийн ангиллаас хамаарсан хувь, хэмжээгээр тогтооно.

Засгийн газрын 2010 оны 273 дугаар тогтоолоор олборлосон түүхий нүүрсний агаарын төлбөр, түүхий нүүрс олборлодог аж ахуйн нэгж, байгууллагыг агаарын бохирдлын төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх Засгийн газрын 2012 оны 139 дүгээр тогтоол гарсан.

Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн төлбөрийг тэдгээрийн ангиллаас хамаарсан хувь, хэмжээгээр дараах байдлаар тогтоосон болно.

Хүснэгт – 7

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн ангилал	CO ₂ хийн ялгарал (г/км)	Жилд ногдуулах төлбөр / төгрөгөөр/
А	121-180	1800
Б	181-250	2100
В	251-350	3500
Г	351-500	5000
Д	501-750	7500
Е	751-ээс дээш	9500

Уул уурхайн салбараас түүхий нүүрс олборлож байгаа аж ахуйн нэгжүүдээс агаарын бохирдлын төлбөр болох 22,439.0 сая төгрөгийг 2012 онд улсын төсөвт оруулсан байна.

2. Уул уурхайн салбараас улс, орон нутгийн төсөвт оруулсан орлого

Уул уурхайн салбарт олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс 2012 оны 12 дугаар сарын байдлаар улс, орон нутгийн төсөвт оруулсан орлогын хэмжээ нь 887 593,1 сая төгрөг байна. /Татварын ерөнхий газрын мэдээллээр/

Уул уурхайн салбараас улсын нэгдсэн төсөвт оруулсан нийт орлогын хэмжээ (Сая.төг)
(Татварын ерөнхий газрын мэдээгээр)

Хүснэгт-8

Д/д	Татварын, төлбөрүүд	Алт	Зэс, молибдени	Бар/мэг	Төмөр	Жонш	Шүүрс	Гялгболд	Бусад	Нийт
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	15,865,126.5	69,418,568.2	1,487,609.4	15,709,257.0	2,654,105.4	50,517,140.8	3,296.1	23,248,306.5	178,903,409.9
2	Бараа, үйлчилгээний НӨАТ	846,144.7	1,791,008.4	4,211,418.4	1,451,784.1	98,932.9	8,826,244.7	24,432.5	52,163,891.0	69,413,856.7
3	Нөөц ашигласны төлбөр	18,208,680.9	102,255,349.4	185,227.2	29,995,055.2	2,926,940.5	137,612,331.3	7,657.6	22,332,573.2	313,523,815.3
4	Үнийн өсөлтийн албан татвар	77,680.2							2,614.5	80,294.7
5	Цалин хөлө түүнтэй адилтгах орлого	6,369,642.3	14,599,500.2	1,777,066.8	1,874,539.9	568,169.9	8,209,739.5	14,750.2	20,885,226.2	54,298,635.0
6	Суутлагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар	171,390.6	86,488.1	68,716.5	1,347,928.2	22,686.6	325,295.8	2,254.3	921,571.3	2,946,331.4
7	Ус, рашаан ашигласны төлбөр	442,322.2	6,898,624.9	17,864.5	24,150.4	42,624.2	520,643.5	1,490.4	397,095.2	8,344,815.3
8	АТБӨЯХ татвар	98,657.8	49,196.4	90,067.1	217,113.6	13,144.8	232,048.7	21,561.0	670,836.5	1,392,625.9
9	Агаарын бохирдлын төлбөр-АТБӨЯХ	7,658.3	3,042.7	5,882.6	10,086.3	986.0	98,523.8	25.4	17,549.7	143,754.8
10	Агаарын бохирдлын төлбөр-Түүхий нүүрс олборлогч		10,178.5		5.0	26,069.8	18,788,941.0		3,624,049.9	22,449,244.2
11	Бусад орлого	714.8	17,852.8	1,932.7	14,132.8	2,616.6	18,452.6	212.5	1,494,697.7	1,550,612.5
12	Бууны татвар	134.0	128.0	182.0	20.0	148.0	86.0	8.0	34.0	740.0
13	Газрын төлбөр	156,787.0	7,751,913.8	48,623.5	138,505.8	47,564.5	842,725.9	599.0	2,150,886.9	11,137,606.4
14	Дундын суутгал - 3%	188.9	1,122.7				348.3		976.8	2,636.7
15	Өвөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	7,942,638.3	153,181,053.9		4,345,130.9	5,895.3	22,441,526.3		7,761,478.3	195,677,723.0
16	Ул хөдлөх хөрөнгийн татвар	137,871.5	2,605,718.3	244,513.5	102,022.4	27,654.5	560,420.1	3,720.7	546,917.9	4,228,838.9
17	Ул хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар	236,190.1		31,930.0	9,880.0		9,891.3		2,651.3	290,542.7
18	Татварын алдангийн орлого	47,506.1		25,826.5	70,376.4	48,539.3	252,025.5	132.5	1,551,399.2	1,995,805.5
19	Татварын торгуулийн орлого	122,473.4		61,934.4	113,042.2	42,786.0	775,927.3	139.2	1,627,049.4	2,743,351.9
20	Татварын хүүгийн орлого	4,746,981.3		380,336.8	9,114.9	17,038.8	319,830.1		9,416,558.1	14,889,860.0
21	Түгэмэл тархалттай ашигт малтмал ашигласан нооцийн төлбөр	19,324.4	32,000.0	145,141.3	44,288.3	48.0	53,817.3		3,269,326.4	3,563,945.7
22	Улсын гэмэлтийн хураамж		11,160.0	309.5	990.0	12.0	986.4		1,255.0	14,712.9
23	2012 онд төлсөн	55,498,113.3	358,712,906.3	8,784,582.7	55,477,423.4	6,545,963.1	250,406,946.2	80,279.4	152,086,945.0	887,593,159.4

Уул уурхайн салбараас улсын төсөвт оруулсан нийт орлогын хэмжээ (сая.төг)

(Уулын ажлын тайлангийн мэдээллээр)

Хүснэгт-9

Татвар, төлбөрүүд	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011	2012*
АМНА төлбөр	69,563.36	98,141.30	121,358.45	235,358.83	532,564.85	684,544.07
Үнийн өсөлтийн албан татвар	259,983.69	419,613.40	217,638.16	466,204.85	-	-
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	93,404.88	119,099.43	132,466.79	213,427.42	299,652.34	277,875.58
НОАТ	15,431.49	31,490.95	24,321.54	43,636.08	212,980.10	136,778.74
Тусгай зөвшөөрлийн төлбөр	1,755.44	4,177.82	3,323.89	56,789.61	3,950.97	7,165.36
Газар ашигласны төлбөр	9,554.08	10,089.21	19,952.72	11,465.98	12,957.87	12,085.99
Ус ашигласны төлбөр	1,776.22	2,400.73	2,493.63	3,776.33	3,552.53	11,191.38
ТХӨЯМ-ын татвар	106.43	189.89	1,020.74	548.21	1,921.16	965.49
Гадаад ажилчдын ажлын байрны төлбөр	520.33	3,377.62	3,078.19	4,865.19	13,907.76	8,020.05
Үл хөдлөх хөрөнгийн татвар	1,458.25	32,682.46	2,647.74	2,913.63	3,779.99	4,321.92
Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын нөхөн төлбөр	2,390.40	5,035.10	11,835.00	4,635.88	2,276.37	2,465.94
Нийт татварын хэмжээ	455,944.57	726,297.91	540,136.86	1,043,622.01	1,087,543.94	1,145,414.51

Уулын үйлдвэрүүдээс улс, орон нутгийн төсөвт оруулсан орлогыг 2010 оны гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулбал бараг 2 дахин нэмэгдсэн боловч 2011 оны гүйцэтгэлээр 4.2%-аар, 2012 оны гүйцэтгэлээр 5.3%-аар тус тус улсын төсөвт хуримтлагдсан байна. Уулын ажлын тайланд өгсөн мэдээгээр 2011 онд 195 орчим аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулсан бол 2012 онд 250 орчим аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулсан байна

Уул уурхайн салбараас 2012 онд улс, орон нутгийн төсөвт оруулсан татварын хэмжээг 2011 онтой харьцуулхад татвар төлөлт өссөн ч энэ нь зөвхөн нүүрсний салбараас оруулж байгаа татвар эзэлж байна. Бусад төрлийн ашигт малтмалаас улсын төсөвт оруулж байгаа орлого буурсан байна.

Уул уурхайн салбараас улсын нэгдсэн төсөвт оруулсан нийт орлогын хэмжээг татвар, төлбөрүүдийн хэмжээгээр тус тус үзүүлвэл:




Уул уурхайн салбараас улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа татварын 59.8 % -ийг ашигт малтмалын нөөц ашигласан төлбөр эзэлж байгаа нь өмнө онуудтай харьцуулахад өндөр байгаа нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг өсөн нэмэгдэх хувиар болон жишиг үнэ зарлаж борлуулалтын орлогоос шууд тооцдог болсонтой холбоотой юм. Мөн ус ашигласны төлбөр огцом өссөн байгаа нь байгаль орчны багц хууль шинэчлэн гарч усны нөөц ашигласны төлбөр шинэчлэн тогтоосон бөгөөд гол мөрний сав газраар өөр өөр тооцогдож байгаатай холбоотой.

Мөн 2012 онд уул уурхайн салбараас улс, орон нутгийн төсөвт оруулсан орлогын хэмжээг ашигт малтмалын төрлөөр бүрээр үзүүлвэл:

Зураг 2

2012* онд улс, орон нутгийн төсөвт оруулсан орлого

/уулын ажлын тайлангийн мэдээллээр/



Тайлбар: АМГ-ын 2013 оны 5 дугаар сарын мэдээлэл болно.

Төсөвт оруулсан орлогоос харахад уул уурхайн салбараас улсын төсөвт оруулж байгаа орлогын 30.5% буюу 406.8 тэрбум төгрөгийг зэс олборлолтоос, 46.2% буюу 616.9 тэрбум төгрөгийг нүүрс олборлолтоос, 5.8% буюу 76.8 тэрбум төгрөгийг алт олборлолтоос, 4.4% буюу 58.7 тэрбум төгрөгийг төмрийн хүдэр олборлолтоос, 0.2% ба 2.1 тэрбум төгрөгийг жонш олборлолтоос, 0.4% буюу 5.0 тэрбум төгрөгийг барилгын материалын олборлолтоос, 12.6% буюу 168.6 тэрбум төгрөгийг бусад ашигт малтмалаас тус тус төвлөрүүлсэн байна.


3. Уул уурхайн салбарын татварын ачааллын судалгаа

Эрдэс баялгийн үйлдвэрлэлд татварын хувь хэмжээ бага бол шавхагдах эрдэс баялгийн ашиглалтаас улсын төсвийн орлогын хэмжээ багасах ба харин хөрөнгө оруулагчдад татварын дарамт их байвал хөрөнгө оруулалт багасах хандлагатай болдог. Иймд төр засгийн болон хөрөнгө оруулагч компаниудын ашиг сонирхлыг уялдуулсан татварын бодлого нэн чухал юм. Уул уурхайн салбар нь асар их хөрөнгө оруулалтыг шаардаж байдаг ба тухайн оруулсан хөрөнгөтэйгөө дүйцэхүйц хэмжээний эрсдлийг дагуулж байдаг. Иймд хөрөнгө оруулагчдын хувьд татварын орчин тогтвортой байх нь чухал асуудлуудын нэг болдог.

Уул уурхайн үйлдвэрлэлийн татварын ачааллын шинжилгээг 2007-2012 оны харьцуулсан байдлаар үзүүлвэл:

Уул уурхайн салбарын татварын ачаалал

Зураг 3




Үүнд: 2007 онд 37%, 2008 онд 25% , 2009 онд 23% болж буурсан бол 2010 онд 41% болж өссөн 2011 онд 29%, 2012 онд 21% болж буурсан байна. Энэ нь 2008 оны 11дүгээр сарын 25-ны өдрийн зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хуулиар өөрчлөлт орж алтны босго үнийг 1 унци алтны үнэ 850 ам доллар болгож өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2009 онд татварын ачаалал буурсан ба ихэнх алт олборлогч аж ахуйн нэгжүүд Монгол банкинд тушаах алтны хэмжээ багассантай холбоотой байна. 2011 онд үнийн өсөлтийн албан татвар хүчингүй болж Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 5-д заасан нэмж ногдуулах өсөн нэмэгдэх ашигт малтмалын төлбөрийн хувь

хэмжээг тогтоосноор татварын ачаалал өссөн байна. 2011 оны 1 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар хүчингүй болсон нь 2011-2012 оны татварын ачаалал бууруулсантай шууд хамааралтай байна.

Уул уурхайн салбарын гол нэр төрлийн ашигт малтмалын 2012 оны байдлаар татварын ачааллын түвшинг тооцож ашигт малтмал тус бүрээр харуулав.

Зураг 4



Үүнээс үзэхэд 2012 онд зэсийн баяжмалд ногдох татварын ачаалал 34%-тай хамгийн их байхад жоншны татварын ачаалал 4%-тай буюу хамгийн бага байна. Алт болон нүүрс 19-23%-тай, гянтболдын баяжмал, төмөр, барилгын материалын татварын ачаалалын дундаж түвшин буюу 10-16% -тай байна. Эндээс ашигт малтмалын өсөн нэмэгдэх нөөцийн төлбөрийн хэмжээ зэсийн баяжмалд өсөн нэмэгдэх төлбөрийн хэмжээ харьцангуй өндөрөөр тогтоосонтой шууд хамааралтай байна. Жоншны татварын ачаалал харьцангуй бага байгаа нь жоншны зах зээлийн үнэ шууд буурсантай шууд холбоотой.

4. Хураамжийн судалгаа

Уул уурхайн салбараас улс, орон нутгийн төсөвт аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, авто тээврийн болон өөрөө явах хэрэгслийн албан татвар, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр, нэмэгдсэн өртгийн албан татвар, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, газар ашигласны төлбөр, ус ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр гэх мэт олон төрлийн татвар, төлбөрийн орлого оруулдаг хэдий ч экспорт, импортын бүтээгдэхүүнд уул уурхайн аж ахуйн нэгжүүд гаалийн байгууллагаас үзүүлсэн үйлчилгээний хураамж зэрэг албан татвараас өөр хэлбэрээр хураамж, төлбөр төлдөг байна.

Гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээний хураамж болон гаалийн байгууллагаас үзүүлсэн үйлчилгээний төлбөрийн хэмжээ

Хүснэгт -10

Д/д	Үйлчилгээний хураамж болон төлбөрийн хураамж	Хураамж болон төлбөрийн хэмжээ
1	Гаалийн тухай хуулийн 79.4.1, 79.4.2-т зааснаас бусад төрлийн горим сонгон гаалийн бүрдүүлэлт хийхэд: -үндсэн мэдүүлэг бүрт -нэмэлт мэдүүлэг бүрт	7000.00 төгрөг 1200.00 төгрөг
2	Нефть, нефтийн бүтээгдэхүүн, газрын тос, газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах зарчмаар Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийхэд: -үндсэн мэдүүлэг бүрт -нэмэлт мэдүүлэг бүрт	7000.00 төгрөг 1200.00 төгрөг
3	Гаалийн хяналтын түр бүсэд захиалгаар үйлчлэхэд (гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээний хураамж дээр нэмж тооцно.) 1 цагийн хураамж: -ажлын өдөрт –ажлын бус цаг, амралт, баярын өдрүүдэд	4000.00 төгрөг 8000.00 төгрөг
4	Гаалийн хилээр татвар ногдуулж нэвтрүүлэх зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлс болон хувь хүний нэр дээр ирсэн татвар ногдуулах улс хоорондын шуудангийн илгээмжид тооцот хуудсаар гаалийн бүрдүүлэлт хийхэд	1200.00 төгрөг
5	Авто тээврийн хэрэгслээр тээвэрлэж буй бараанд ачааны манифест (А1) бичихэд манифест тутамд	3000.00 төгрөг
6	Барааг гаалийн баталгаат бүсэд оруулахад төлөх шимтгэлийг барааны үнийн дүнгээс тооцон гаалийн баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхлэгч төлнө.	0.1 хувь
7	Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр гадаад худалдааны барааны статистик мэдээллийг гаргаж өгөхөд: -сар, улирлын гадаад худалдааны барааны статистик мэдээлэл -хагас, бүтэн жилийн гадаад худалдааны барааны статистик мэдээлэл -тусгайлсан судалгаа (1 нүүр) -лавлагаа(1 удаа)	5000.00 төгрөг 10000.00 төгрөг 4500.00 төгрөг 1500.00 төгрөг
8	Гаалийн үндсэн болон нэмэлт мэдүүлэг, гаалийн мэдүүлгийн хавсралт, ачааны манифестыг зуучлагч байгууллагуудад худалдахад: -1 багц нь	1200.00 төгрөг
9	Экспортод гаргах уул уурхайн бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийн хураамж 1000 кг тутамд : - Үүнээс 1000 кг нүүрс тутамд	1000.00 төгрөг 1500.00 төгрөг
10	Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд тавьсан нэг удаагийн ломбоны үнэ	1000.00 төгрөг

Монгол улсын Засгийн газраас 2002 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 108 дугаар тогтоолоор “Хилийн боомтын гаальд ажиллаж буй байгууллагуудын үйл ажиллагааг нэг цэгийн үйлчилгээнд хамруулж, улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд ногдуулж буй татвар, хураамжийг гаалийн байгууллагаар дамжуулж улсын төсөвт хураахаар зохицуулсан байна.

2010 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар экспортод гаргах уул уурхайн бүтээгдэхүүнд гаалийн бүрдүүлэлт хийхэд тооцон авч байсан үндсэн мэдүүлгийн 7000.0 төгрөг, нэмэлт мэдүүлгийн 1200.0 төгрөгийн

гаалийн бүрдүүлэлтийн хураамжийг авахгүй байхаар тогтоосон болно.

Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 188 дугаар тушаалын хавсралтаар баталсан Улсын хилээр гаргах бараа, нэвтрэх тээврийн хэрэгсэлд ногдуулах хураамжийн хэмжээг дор үзүүлэв.

**Улсын хилээр гаргах бараа, нэвтрэх тээврийн хэрэгсэлд
ногдуулах хураамж**

Хүснэгт -11

д/д	Тээврийн хэрэгслийн ачааны хэмжээ	Хураамж /төгрөгөөр/
1	5000 хүртэл кг ачаанаас	10000
2	5001-10000 кг ачаанаас	18000
3	10000-15000 кг ачаанаас	26000
4	15001-20000 кг ачаанаас	34000
5	20001-25000 кг ачаанаас	42000
6	25001-30000 кг ачаанаас	50000
7	30000 кг-аас дээш ачаанаас	60000
Экспортод гарч буй нүүрсэнд ноогдуулах хураамж		
1	30000 кг хүртэл нүүрснээс	10000
2	30000 кг-аас дээш нүүрсэнд	20000

Улсын мэргэжлийн хяналтын газрын даргын 2006 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 521 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан Улсын хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгсэлд хийх ариутгал, халдваргүйжилтийн үнийг дурьдвал:

Ариутгал, халдваргүйжүүлэлтийн үнэ

Хүснэгт -12

д/д	Тээврийн хэрэслийн төрөл	Хэмжих нэгж	Төлбөр /төгрөг/
1	8 хүртэлх хүний суудалтай	ш	1000
2	8-аас дээш хүний суудалтай	ш	2000
3	5 хүртэлх тоннын даацтай	ш	3000
4	5-аас дээш тоннын даацтай	ш	4000
5	Суудлын нэг вагон /чингэлэг/	ш	5000
6	Ачааны нэг вагон /чингэлэг/	ш	15000
7	Дотоодын онгоц	ш	15000
8	Гадаадын онгоц	ш	48000
9	Бараа бүтээгдэхүүн	м3	50
10	Талбай	м3	50

ДҮГНЭЛТ

1. Уул уурхайн олборлох салбараас улсын төсөвт оруулж байгаа татварын ачаалал урд онуудтай харьцуулахад буурсан нь зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар хүчингүй болсонтой холбоотой байна.
2. Төсөвт оруулсан орлого нэмэгдсэн гол нөлөө нь нүүрсний бүтээгдэхүүний хэмжээ, ус ашигласны төлбөр, жижиг үнээс хамаарч өсөн нэмэгдэх татвар авдаг болсон зэрэг нь нөлөөлсөн байна.
3. Татварын ачаалал буурсан байна. Энэ нь аж ахуйн нэгжийн тоо өсч бүтээгдэхүүн борлуулалт буурсан нь нөлөөлсөн. Татварын хамгийн өндөр ачаалал нь зэсэн дээр байгаа нь Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тооцох хувь нь өндөр байгаагаас шалтгаалан ачаалал өндөр байна. Мөн алтны ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс авах татварын хэмжээ өндөр зэрэг нь татварын ачаалал өндөр гарахад нөлөөлж байна. Өсөн нэмэгдэх нөөцийн төлбөрийн сөрөг үр дагвар нь алт, зэсийн бүтээгдэхүүнд ногдуулах татварын хэмжээ эрс нэмэгдсэн нь зах зээлийн үнийн өсөлттэй шууд холбоотой байна. Үүнээс үүдэн алтны олборлолтын хэмжээ эрс буурч зэсийн орд газруудыг ашиглах, эхлүүлэх боломж үндсэндээ хаагдсан байна.

Ашигласан материал

1. Хууль тогтоомж, эмхэтгэлүүд
 - Монгол Улсын Татварын ерөнхий хууль
 - Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль
 - Монгол Улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
 - Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
 - Агаарын бохирдлын тухай хууль
 - Гаалийн тухай хууль
2. Бюлетень /УСГ/ 2007-2012 он
3. Б.Бямбадавга, Ц. Цэгц , Д. Маасүрэн, Б. Сүхтулга
“Монгол Улсын Уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчин ба татварын ачааллын судалгаа” 2011 он
4. Интернетийн эх сурвалж
 1. <http://www.worldgrowth.mn/>
 2. <http://www.nambc.org/docs/Dr.%20James%20Otto%20--%20Mongolia%2>
 3. www.infomine.com
 4. Сангийн яамнаас авсан мэдээ
 5. АМГ, УУХ, НЭЗСТ-ийн уулын ажлын төлөвлөгөө тайлангийн мэдээллийн системээс 2011, 2012 оны мэдээлэл
 6. Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас авсан мэдээлэл
 7. Татварын ерөнхий газрын мэдээлэл

